



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 74,167,277.00 (далан дөрвөн сая нэг зуун жаран долоон мянга хоёр зуун хорин долоон) төгрөгийн балансын үнэ, 63,191,849.00 (жаран гурван сая нэг зуун ерэн нэгэн мянга найман зуун дөчин есөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Монгол улсын их сургуулийн Археологийн судалгааны төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Г.Ёндон, Монгол улсын их сургуулийн Археологийн судалгааны төвийн захирал Ц.Төрбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

132003042
2022.09.29 22:41 Нуралдаан.бсх

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын Газрын
2022 оны 07 дүгээр сарын 27-ны өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт



**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВД БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
				(төгрөг)	
1	Автомашин NISSAN Patrol Y61, улсын дугаар 20-02 орх	2007	74,167,277.00	63,191,849.00	10,975,428.00
Нийт дүн			74,167,277.00	63,191,849.00	10,975,428.00
Нийт дүн			(далан дөрвөн сая нэг зуун жаран долоон мянга хоёр зуун хорин долоон)	(жаран гурван сая нэг зуун ерэн нэгэн мянга найман зуун дөчин есөн)	(арван сая есөн зуун далан таван мянга дөрвөн зуун хорин найман)